

“Туравдагч хөрш”-ийн бодлого ба Монгол, Туркийн харилцаа

Б.Батхишиг*

Монгол Улсын Их Хурал 2011 оны 2 дугаар сард Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн баталсан бөгөөд уг баримт бичигт “туравдагч хөрш”-ийн бодлогыг анх удаа албан ёсоор тунхаглаж, уг бодлогын хүрээнд ямар улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг тодорхой зааж өгсөн юм. Тухайлбал, уг үзэл баримтлалын 14.2-т “АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж заасан билээ. Ийнхүү БНТУ-ыг манай гуравдагч хөрш гэдгийг албан ёсоор зарласан юм.

“Туравдагч хөрш”-ийн бодлогыг яагаад тунхаглав гэдэг асуулт гарах нь мэдээж. Монгол Улс бол ОХУ, БНХАУ гэсэн хоёр том гүрний дунд оршдог улс. Иймд энэ хоёр хөрштэйгээ найрсаг харилцаатай байх, тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх нь манай улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл юм. Манай улс ОХУ, БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж, улмаар түүнийг улам иж бүрэн шинжтэй болгохыг зорьж байна.

Монгол Улсаас БНТУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, доктор, дэд профессор

Үүний зэрэгцээ манай улс үндэсний аюулгүй байдлаа бататгах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахын тулд өндөр хөгжилтэй дэлхийн бусад тэргүүлэх улс, холбоотой харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага, сонирхол бий. Үүнийг бид “гуравдагч хөрш”-ийн бодлого гэж томъёолсон. Тэгэхээр энэ бодлогын агуулга, мөн чанарын талаар хэдэн үг хэлье.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого гэдэг бол **ювны өмнө** газар зүйн бус, улс төр, эдийн засаг, гадаад бодлогын ойлголт юм. Энэ нь аль нэг гурав дахь орныг бус, харин өрнө, дорнын нөлөө бүхий улс орнуудыг хамтруулан манай гадаад харилцааны нэг гол субъект болгон авч үзэж байгаа хэрэг юм.

Хоёрт, энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийг зөвхөн хоёр их хөршийнхөө төдийгүй дэлхийн ба бүс нутгийн нөлөө бүхий улсуудын туслалцаа, дэмжлэгтэйгээр хангах бодлого мөн.

Өөрөөр хэлбэл, энэ нь хоёр их хөршөө үгүйсгэсэн бодлого биш, харин хоёр их хөрштэйгээ болон дэлхийн нөлөө бүхий бусад улстай харилцаа, хамтын ажиллагаагаа нэгэн зэрэг хөгжүүлэх бодлого юм.

Гуравт, энэ бол 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш манай улсын ардчилал, шинэчлэлийг дэмжиж, тусалж ирсэн дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий улсуудтай шинэ тутам тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа өргөтгөн гүнзгийрүүлэх, ардчиллын үнэт зүйслийг хуваалцан хөгжүүлэх бодлого юм.

Дөрөвт, энэ бол аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилсэн бодлого, дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий улсуудын тус улс дахь ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх бодлого юм.

Хэдийгээр 2011 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа албан ёсоор томъёологдсон гэсэн ч “гуравдагч хөрш”-ийн бодлого Монгол Улсын гадаад бодлого дахь цоо шинэ зүйл биш ээ.

Одоогоос 100 гаруй жилийн өмнө буюу 1911 онд манай улс Манжийн эрхшээлээс гарч, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа Богд хаант Монгол улсын Засгийн газар АНУ, Япон, Их Британи, Герман, Франц, Голланд зэрэг улсын Засгийн газарт хандан захидал илгээж, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, худалдааны болон бусад харилцааг хөгжүүлэх санал тавьж байжээ.

Харин 1921-1990 онд манай улс Зөвлөлт Холбоот Улс болон социалист гэгдэх системийн хүрээлэлд байсан учир “гуравдагч хөрш”-ийн бодлого явуулах хэрэгцээ шаардлага болон боломж, бололцоо байгаагүй юм.

Гагцхүү 1990 онд ардчилсан хувьсгал ялж, ардчилал, шинэчлэлийн замд тууштай орсноос хойш манай улс өөрийн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах боломжтой болж, үүний хүрээнд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэх болсон юм.

Одоо би хэлэх үгийнхээ 2 дахь хэсэгт Монгол Улс яагаад Туркийг “гуравдагч хөрш”-ийн бодлогодоо хамруулсан, түүнийгээ хэрэгжүүлэх талаар юу хийж буй тухайд товч ярья.

Манай улс БНТУ-ыг гуравдагч хөршийнхөө нэг гэж тодорхойлсон нь дараах хүчин зүйлстэй холбоотой. Үүнд:

Нэгд. Монгол, Турк нь түүхийн эртний гүн хэлхээ холбоотой, ижил төстэй хэл, соёлтой улсууд. Одоогоос хэдэн зуу, хэдэн мянган жилийн тэртээ Монгол, Турк ард түмнүүд айл зэргэлдээ аж төрж байсан, түүний ул мөр болох эртний Түрэгийн хөшөө дурсгал Монголын нутагт олноор хадгалагдан үлджээ.

Хоёрт. эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд 17-д ордог бөгөөд 2023 онд эхний 10-т орох зорилт тавьж буй Турктэй эдийн засаг болон бусад салбарт хамтран ажиллах нь манай үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Гуравт. манай улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явцыг Турк улс эхнээс нь дэмжиж, улс төр, эдийн засаг, техникийн тусламж үзүүлж ирсэн.

Дөрөвт, сүүлийн жилүүдэд манай иргэд Туркт олноор зорчих, ажиллах, суралцах болсон.

Тавд, манай улс дэлхийн төвд орших Туркээр дамжин Европ, Америк, Африк хүрэх тээврийн шинэ гарцыг нээж ашиглах боломжтой.

Зургаад, Турк нь OECD, НАТО-гийн гишүүн орны хувьд манай үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, гадаад таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Бид Туркийг гуравдагч хөршөө гэж зарлаад орхих биш, харин гуравдагч хөршийн хэмжээ, түвшинд харилцаж, хамтын ажиллагаагаа өргөтгөх шаардлагатай. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд нэлээд ахиц, дэвшил гарч байна. **Тухайлбал**, 2012 оны 7 дугаар сараас Истанбул-Улаанбаатарын хооронд шууд нислэг эхэлж одоо 7 хоногт 3 удаа онгоц нисэж байна. Ингэснээр манай иргэд зөвхөн Москва, Бээжин, Сөүлээр дамжин Европ, Америк, Африк тивд хүрдэг байсан бол одоо Туркээр дамжин эдгээр тивд илүү дөт замаар хүрэх гуравдагч зам, гуравдагч гарцыг нээлээ.

Цаашид Истанбул-Улаанбаатар-Сөүл чиглэлд агаарын ачаа тээврийн зам нээх боломж бий. Ингэвэл манай улс Европ, Азийг холбосон агаарын ачаа тээврийн төв болох юм.

Мөн Босфорын хоолой дээгүүрх гурав дахь гүүр баригдаж, тэндээс Дундад Азиар дамжин Хятадын Шинжаан Уйгур хүрэх төмөр замын шинэ төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ шинэ “торгоны зам”-д манай улс нэгдэх сонирхолтой байгаа юм. Энэ нь далайд гарцгүй манай улсын хувьд Европ хүрэх шинэ, дөт / бараг 1000 км татуу/ зам болох ирээдүйтэй.

Ийнхүү “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд дэлхийд гарах гуравдагч замыг нээж эхэлж байна.

Хоёрт, Туркийн Засгийн газар 2007 оноос эхлэн Монголын иргэдийг нутагтаа 30 хүртэлх хоног визгүй зорчуулах шийдвэрийг дангаараа гаргасан. Харин 2013 оны 10 дугаар сард хоёр улсын иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээрт гарын үсэг зурснаар 2014 оноос эхлэн Туркийн иргэд Монголд бас визгүй зорчих боллоо. Энэ нь хоёр

улсын хооронд аялал жуулчлал, бизнес, худалдаа, соёл, боловсрол гээд бүхий л төрлийн харилцааг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүллээ. Гадаадын бусад улсын иргэд Монголыг сонирхож очдог. Харин Туркийн иргэд Монголыг зорьж очих ёстой. Учир нь Монголд Түрэгийн хөшөө, дурсгалууд олон байгаа. Хөршүүд бие биенлүгээ чөлөөтэй зорчиж, орж гарч байх учиртай. Бид ийм нөхцлийг бүрдүүллээ. Цаашид иргэдийн визгүй зорчих хугацааг уртасгах талаар ярьж хэлэлцэж байна.

Гуравт. хоёр улсын боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаа өргөжиж байна. Эдүгээ Туркт Монголын 800 гаруй оюутан суралцаж байгаагийн тал нь Туркийн Засгийн газрын зардлаар суралцаж байна. Жил бүр Монголын 50-60 оюутан Туркийн их сургуулиудад элсэж байна.

Монголд Туркийн 5 дунд сургууль ажиллаж байгаа. Энэ бүхний үр дүнд турк хэлээр ярьдаг Монголын иргэдийн тоо ихэд өслөө. Хөршүүд бие биентэйгээ харилцаж, ойлгохын тулд хэл нэн чухал.

Мөн Туркт Монгол судлал хөгжиж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хажеттепе их сургуульд Монгол судлалын анхны төв байгуулагдаж, энэхүү хурлыг зохион байгуулж байна. Хэдхэн хоногийн өмнө Гази их сургуульд Монгол, Турк судлалын асуудлаар эрдэм шинжилгээний хурал бас болсон.

Хөршүүд хэл, соёлоо харилцан судлах хэрэгтэй.

Дөрөвт. эдийн засгийн хамтын ажиллагаа нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Монгол орны газрын хөрсөн доор асар их баялаг байна. Газрын хөрсөн дээр 50 гаруй сая мал сүрэг бэлчиж, түүний ашиг шим, түүхий эд гээд байнга нөхөн сэргээгдэж байдаг бас их баялаг бий. Турк улс эдийн засгийн чадавхийн хувьд хүчирхэгжиж, шинэ технологи, ноу-хау ихээхэн нэвтэрч байна. Монголын байгалийн баялаг, нөөцийг Туркийн хөрөнгө оруулалт, технологитой холбовол гарах үр дүн нь аль аль талдаа ихээхэн өгөөжтэй гэж бодож байна. Тухайлбал, манай улс жилд 10 сая гаруй малын арьс шир бэлтгэж, ихэнхийг нь боловсруулалтгүйгээр гадагш гаргаж байна. Гэтэл Туркэд арьс шир боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн хийх технологи, туршлага байна. Иймд хоёр улс энэ салбарт хамтран

ажиллах хэрэгтэй. Үүнээс гадна орон сууцны барилга, хот байгуулалт, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гээд хамтран ажиллах боломжтой олон салбар бий бөгөөд тэдгээрт хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж эхлээд байна. Сүүлийн үед Туркээс Монголд хийх хөрөнгө оруулалт өсөх хандлагатай боллоо. Хэрэв 1990-2013 онд Туркээс Монголд оруулсан хөрөнгө оруулалт нийтдээ 8 сая доллар байсан бол зөвхөн 2014 онд 170 сая долларын хөрөнгө оруулалт хийх гэрээ, хэлцэл хийгдлээ. Хөрш орнуудын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалт бусад орныхоос илүү их байх учиртай.

Тавд. хоёр улсын аюулгүй байдал, батлан хамгаалах, хууль зүй, шүүх, прокурор, цагдаа, аудит, статистик зэрэг янз бүрийн салбар, байгууллагын хооронд шууд харилцаа тогтоож, хөгжүүлж байна. Энэ бүхэн манай хоёр ард түмнийг улам бүр ойртуулж байна.

Энэ бүхнээс дүгнэхэд эдүгээ Монгол, Туркийн хооронд иж бүрэн түншлэлийн харилцаа үнэхээр бодитой хэрэгжиж байна. БНТУ-ын Ерөнхий сайд Р.Т.Эрдоан 2013 онд Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр гаргасан хамтарсан мэдэгдэлд хоёр улсын харилцааны түвшинг цаашид ахиулж, “стратегийн түншлэл”-д хүргэх хэтийн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын гуравдагч хөрш болсон Турк улстай харилцаагаа ийнхүү түвшин, шат ахиулан хөгжүүлэх нь манай гадаад бодлогын чухал зорилт болж байна.

Би энд “гуравдагч хөрш” хэмээх Монголын гадаад бодлогын нэр томъёоллын тухай албаны үгээр ярьлаа. Энгийн үгээр хэлбэл, Монгол, Туркийн ард түмэн угаасаа, түүхээсээ сайн хөршүүд байсан, одоо ч байх учиртай гэдгийг онцлон хэлье.

Нэг удаа би Туркийн Батлан хамгаалахын сайд Исмет Иылмаз гуайд Турк улс манай гуравдагч хөрш болсон тухай хэлэхэд тэрбээр “Бид танай гуравдагч биш дугааргүй хөрш шүү” гэж хэлж билээ.

Нээрээ айл саахалт явсан, шууд хөршүүд байсан ард түмнүүд бидэнд ямар нэгэн дугаар хэрэггүй ч байж мэдэх юм.